

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

Дараах тохиолдлуудыг уншаад 1-6 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

МАНДАЖ БУЙ НАР	НЭЭЛТТЭЙ ХИЧЭЭЛ
Би амьдарч буй гэр бүлээ “Мандаж буй нар” гэж төсөөлдөг. Нар мандахаараа харанхуйн бүх зүйлсийг гэрэлтүүлж ямар гоё харагддаг билээ дээ. Учир нь тэр нарыг мандуулах нь аав, ээж бид гурвын аль алиных нь оролцоо хамгийн чухал гэж би боддог. Тухайлбал: миний хувьд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, аливаа асуудал гарвал аав ээжтэйгээ ярилцах, олон талаас нь хандах, аав, ээжээ хайрлах, хүндэтгэх, аав ээжийнхээ үгэнд орох гэх мэт.	Болороо багш 7а ангийн сурагчдад “Хүүхдийн эрх ба үүрэг” гэсэн сэдэвтэй хичээл орсон. Хичээл эхлэхэд 7а ангийнханд бичил хэмжээний видео үзүүлж тухайн видеоны гол санааг суралцагчдаар тайлбарлуулсан. Сурагчдын гаргаж ирсэн санаанд тулгуурлан асуудалд дэвшүүлж сурагчдаар шийдвэрлүүлсэн байна. Хичээлийн ард суусан сургалтын менежер Болороо багшийн хичээл заах арга зүйг өндрөөр үнэлж цалингийн урамшуулал олгожээ.
ФАНАТ	РОК ХӨГЖИМ
Сүрэн, Билэгт хоёр телевизээр FIFA үзэж байхдаа санаа бодол нь зөрчилдөж маргаан үүссэн. Тэр хоёр зөрчилдсөн ч гэсэн нэгнийхээ дэмждэг багийн тоглогчийг хэн хэн нь илүү гэдэг санаан дээр зөрчилдсөнөө ойлгож эхэлсэн билээ. Гэсэн ч Билэгт Сүрэнд буулт хийж чадалгүй өөрийн дэмждэг багийнхаа тоглогчийг бусад багуудтай харьцуулан илүү гэж зөрчилдсөөр байсан. Тэрхүү зөрчил нь илүү хурцадмал байдалд орж Билэгт Сүрэнгийн гар руу цохин авчээ.	“Б” болон “Г” хоёр өглөө эрт гүйлтийн талбайд гүйхээр болжээ. Өглөө эрт гүйж явахад нь сандал дээр сууж байсан нэгэн залуугийн урт хар үс болон өмссөн хувцсыг нь хараад эмэгтэй хүн шиг харагдаж байна хэмээн инээлдэв. Харин тэр залуу рок хөгжим сонирхдог бөгөөд хард рок, метал урсгал ихэвчлэн гүн, хүчтэй, заримдаа бараан сэдэвтэй байдаг. Харин хар өнгийн хувцас, урт үс нь тэр уур амьсгалыг бүрдүүлдэг байна.

1. Аль тохиолдол зөвхөн хоёрдогч бүлгийг дүрсэлж байна вэ? /1оноо/
 А. Фанат В. Мандаж буй нар С. Нээлттэй хичээл D. Рок хөгжим
2. Дээрх дөрвөн тохиолдлоос бичигдмэл хэм хэмжээгээр гишүүдийн харилцааг зохицуулсан тохиолдлуудыг олоорой. /1оноо/
 А. Фанат В. Мандаж буй нар С. Нээлттэй хичээл D. Рок хөгжим
3. Зөрчил маргааны хоёр дахь үе шатад аль хэсэг нь хамаарч байна вэ? /2 оноо/
 А. Тэр хоёр зөрчилдсөн ч гэсэн нэгнийхээ дэмждэг багийн тоглогчийг хэн хэн нь илүү гэдэг санаан дээр зөрчилдсөнөө ойлгож эхэлсэн билээ.
 В. Билэгт Сүрэнд буулт хийж чадалгүй өөрийн дэмждэг багийнхаа тоглогчийг бусад багуудтай харьцуулан илүү гэж зөрчилдсөөр байсан.
 С. Тэрхүү зөрчил нь илүү хурцадмал байдалд орж Билэгт Сүрэнгийн гар руу цохиж бэртэл учруулжээ.

- D. Сүрэн, Билэгт хоёр телевизээр FIFA үзэж байхдаа санаа бодол нь зөрчилдөж маргаан үүссэн.
4. Дээрх дөрвөн тохиолдолд үзүүлсэн дүрслэлийг нэгтгэн тодорхойлоорой. /2 оноо/
 A. Хувь хүн ба нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцаа болон соёлын олон янз байдлын тухай өгүүлсэн.
 B. Нийгмийн анхдагч, хоёрдогч бүлэг, харилцааны бүс, зөрчил маргаан, түүний үе шатууд болон соёлын олон янз байдлын тухай өгүүлсэн.
 C. Нийгмийн бүлэг болон нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцаа, зөрчил маргаан, түүний үе шатуудын тухай өгүүлсэн.
 D. Нийгмийн бүлэг болон харилцааны бүс, зөрчил маргаан, зөрчил маргааны үе шат, хувь хүний соёлын бүрдэл хэсгүүдийн тухай өгүүлсэн.
5. Аль тохиолдол зөвхөн соёлын олон янз байдлыг дүрсэлж байна вэ? /1оноо/
 A. Мандаж буй нар B. Фанат C. Нээлттэй хичээл D. Рок хөгжим
6. “Рок хөгжим” тохиолдолд гарч буй инээлдэж байгаа хүмүүст та ямар хэм хэмжээг баримтлахыг зөвлөх байсан бэ? /2 оноо/
 A. Хүлээцтэй байдлыг эрхэмлэж бусдын соёлыг хүндэтгэн, хэн нэгнийг гомдоохгүй байж, тэр залуугаас эелдэг найрсгаар уучлалт хүсэх
 B. Тэр залуутай нийтэч нийлэмжтэй байж, хэн нэгнийг гомдоох зүйл хийхгүй байх тал дээрээ анхааран эелдэг найрсгаар уучлалт хүсэх
 C. Таныг харахад эмэгтэй хүн шиг харагдаж байна гэж үнэнээ хэлж үнэнч шударгаар хандах, түүнтэй нийтэч нийлэмжтэй байж эелдэг, найрсгаар хандах
 D. Тэр залуугийн сонирхдог урлаг, дуу хөгжмийг нь болиулж үс болон өмссөн хувцсыг нь солиулах тал дээр ярилцаж, түүнд эелдэг найрсгаар хэлэх
7. Дараах жишээнүүдээс аль нь хэл ярианы соёлд тавигдах шаардлага гэдэг ойлголтыг бүрэн илэрхийлж байна вэ? /2 оноо/
 A. Очироо технологийн хичээлийн дадлага ажил дээрээ тулгуурлан өвөөгийнхөө гэрийн угсардаг ширээг янзалж өгсөн.
 B. Лхагваа ангийнхандаа үзүүлэхээр нутгийнхаа шүтээний (уул, ус, ан амьтан, домог, түүх, соёл гэх мэт) тухай тодорхой шинж чанарыг илэрхийлсэн макет хийсэн.
 C. Балдан сургуулийнхаа илтгэх урлагийн клубт явахаар шийдсэн. Энэхүү клубт орсон гол шалтгаан нь бусдын өмнө ярихдаа нэг үгийг олон давтахгүй байх юм.
 D. Оргил бусад хүнтэй, байгальтай, эд юмстай харилцах харилцааг журамлаж, зөв сайхан амьдрах арга ухаанд суралцах зүйлийг эцэг, эхийн хүмүүжлээр сурсан.
8. Мэдлэг гэсэн ойлголтыг аль нь зөв тодорхойлсон байна вэ? /1 оноо/
 A. Мэдлэг бол хамт олон, бие хүний зан төлөв, үйлдлийг тодорхой шалгуурт нийцэж байна уу, үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явц юм.
 B. Мэдлэг бол зөв, буруу, сайн, муу, сайхан, муухай, шударга, шударга бус гэх мэт олон янз байна.
 C. Мэдлэг бол үнэлэмжийг хувь хүн өөриймшүүлсэн хэр хэмжээ, түвшнийг илэрхийлдэг ойлголт юм.
 D. Мэдлэг бол хувь хүний танин мэдэх үйл ажиллагааны үр дүнд бий болсон амьдралдаа ухаалаг авч явах, асуудлыг зөв шийдэх арга хэрэгсэл юм.
9. Үйлдвэрлэн бий болгох эдийн засгийн баялагт аль нь хамаарах вэ? /1 оноо/
 A. Ашигт малтмал B. Агаар мандал C. Будаа D. Урсгал ус

10. Нийтийн өмчид аль нь хамаарахгүй вэ?

/1 оноо/

- A. Гандандэгчилэн хийд
B. Хадгаламжийн дэвтэр
C. Сүхбаатарын талбай
D. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн

Тохиолдлыг уншаад 11-12 хүртэлх даалгаврыг гүйцэтгээрэй.

Зээл

Хулан мэдээлэл технологи харилцаа холбооны чиглэлээр ажилладаг бөгөөд сарын цалин 3 сая 800 мянган төгрөг. Тэр аав, ээжийнхээ гэрт амьдардаг тул өөрийн гэсэн гэр оронтой болохыг хүсдэг бөгөөд түүний хадгалсан мөнгө нь хангалттай биш байлаа. Учир нь түүний нэг сарын хүнсний хэрэглээ нь дунджаар 500 мянган төгрөг, бусад хэрэглээ нь 400 мянган төгрөг болдог. Харин эрүүл мэндийн, нийтийн унаа, англи хэлний сургалтын төлбөр гэх мэт үйлчилгээнд 940 мянган төгрөг төлдөг. Хулан өөрийн гэсэн гэр оронтой болох хүсэлтэйг аав, ээж нь мэдээд цалингийн зээл аван шинэ байр авч өгчээ.

11. Хэрэгцээ гэсэн ойлголтыг илэрхийлж байгаа хэсгийг олоорой.

/2 оноо/

- A. сарын цалин 3 сая 800 мянган төгрөг
B. аав, ээж нь цалингийн зээл авсан
C. хадгалсан мөнгө нь хангалттай биш
D. өөрийн гэсэн байртай болохыг хүсдэг

12. Хулангийн нийт хэрэглээ болон зарлага нь хэдэн төгрөг болж байна вэ?

/2 оноо/

- A. Нийт хэрэглээ болон зарлага нь 1,840,000 төгрөг
B. Нийт хэрэглээ болон зарлага нь 1,960,000 төгрөг
C. Нийт хэрэглээ 900,000 төгрөг, зарлага нь 940,000 төгрөг
D. Нийт хэрэглээ 900,000 төгрөг, зарлага 40,000 төгрөг

13. Хэрэгцээ гэсэн ойлголтыг аль өгөгдлүүд зөв тодорхойлсон байна вэ?

/2 оноо/

1. Амьдралын явцад олон төрлийн хэрэгцээ шинээр бий болдог.
2. Хэрэгцээ бол хүсэлтэй адил зүйл бөгөөд бүх хэрэгцээ ижил чухал юм.
3. Эхийн сүү, эцэг эхийн хайр халамжид өсөж өндийх нь заяагдмал хэрэгцээ юм.
4. Зөвхөн мөнгөтэй бол бүх хэрэгцээ хангагддаг тул хэрэгцээ зөвхөн материаллаг юм.

- A. 1, 2
B. 1, 4
C. 1, 3
D. 2, 3

14. Нэр авах, амьдрах, эрүүл өсөж торних, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох, тусламж авах зэрэг боломжууд дараах ойлголтуудын алинд нь хамааруулахад тохиромжтой вэ?

/1 оноо/

- A. Эрх чөлөө
B. Хүүхдийн эрх
C. Хүүхдийн оролцоо
D. Хүүхдийн эрхийн зарчим

15. Дараах жишээнээс аль нь хөгжих эрхийг илэрхийлж байна вэ? /1 оноо/
- Мөнхөө хэвлэл мэдээллээр яагаад жагсаал цуглаан хийж байгаагаа жишээ, баримтад тулгуурлан илэрхийлсэн.
 - Иргэн Д болон Ё нар нэр төрөө хамгаалуулахаар захиргааны байгууллагад гомдол гаргажээ.
 - Болд болон Үжин хоёр үр хүүхдийнхээ амьдрах өрөө тасалгаа болон хоол, хүнсэнд нь анхаарч ач холбогдол өгдөг.
 - Дулам Япон улсын Kyushu University сургуульд мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжүүлэхээр болжээ.
16. Бидний эрх цаасан дээр бичигдэх төдий бус, бид хаана байна, тэнд хэрэгжиж байх ёстой. Тэгвэл эрх нь зөрчигдөж байгаа жишээг олоорой. /2 оноо/
- Багш болон ангийнхнаа хүндэтгэж хичээл эхлэхээс өмнө ангид орж ирэх
 - Ангийнхаа ширээнийхээ найзтай ширээний талбайг тэнцүү ашиглах
 - Хурдан морь унадаг хүүхдийг хамгаалах зорилгоор тусгай хувцас өмсгөх
 - Хүүхдийн тоглоомын талбай дээр барилга барих шийдвэр гарах
17. Хуульд хамаарах ойлголтыг аль өгөгдлүүд зөв тодорхойлсон байна вэ? /2 оноо/
- Хуулийг дагаж мөрдөх нь өөрийн болон бусдын эрхийг хэрэгжүүлэх, гол арга зам юм.
 - Хуулийг Монгол улсын засгийн газар, шүүхийн тогтолцооны байгууллага батлан гаргадаг.
 - Хууль нь хүний эрхийг хамгаалах хэрэгсэл болдог ч, хүмүүсийн хоорондын бүх харилцааг зохицуулдаг.
 - Хууль, дүрэм, журмыг хүний эрхийг хамгаалах зорилготойгоор батлан гаргадаг.
- A. 1, 2 B. 1, 4 C. 1, 3 D. 3, 4
18. Үйл ажиллагааны хэд хэдэн чиглэл, асуудлыг шийдэх олон хувилбаруудаас аль оновчтойг нь сонгох үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
- Хамтын удирдлага
 - Хувилбаруудыг сонгох
 - Шийдвэр гаргах
 - Шийдвэрийг хэрэгжүүлэх
19. Олуулаа хэлэлцэж асуудлыг шийдвэрлэхийн тухай ойлголтод аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
- Цувж явсан бараас цуглаж суусан шаазгай дээр
 - Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй
 - Бүгдийн эхэн эх, бүтээхийн эхэн эв
 - Ганзага гөлөм эмээлийн чимэг, гарамгай хөдөлмөр биеийн чимэг
20. Шийдвэр гаргасан үйл явцаа хянах бүдүүвчийг зөв дараалал байршуулаарай. /2 оноо/
- Өгөгдөл: /а-Сонголт хийх, b-Шийдвэрийг хэрэгжүүлэх, c-Шийдвэрлэх асуудлаа ойлгох, d-Хувилбар боловсруулах, e- Шийдвэрлэх асуудлаа олох/



- A. 1e2c3d4a5b B. 1e2c3d4b5a C. 1c2e3d4a5b D. 1c2e3a4d5b